

National
Datacenter



ХАЛДЛАГАД ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ БАГ

Нууц үгийн эрин үе дуусч байна: Хэрэглэгч нууц үг хэрэглэхээ больж буй

дадал нь энэ өөрчлөлт хийгдэх дөхөж буйг илэрхийлж байна.

Нууц үг ашиглахаа болино хэмээх яриа гараад нэлээдгүй хугацаа өнгөрсөн хэдий ч өнөөдрийг хүртэл интернет орчинд бид өөрсдийгөө баталгаажуулахдаа нууц үгийг түлхүү ашигласаар байна. Ингэхдээ дундаж хэрэглэгч 100 гаруй хаягийг нууц үг ашиглан удирдаж байна. Гэвч кибер аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл, технологийн хөгжил мөн хэрэглэгчдийн зан төлөвийн өөрчлөлт зэрэг нь нууц үг ашиглах энэхүү эрин улиран өнгөрч магадгүй гэдгийг илэрхийлж байна.

Хэрэглэгчид нууц үгээс бусад баталгаажуулалтын аргуудад нээлттэй хандаж байна

Эмзэг мэдээлэл алдагдаж буй маш олон тохиолдлоос үүдэн хэрэглэгчид аюулгүй байдалдаа анхаарах болсон бөгөөд үүгээр зогсохгүй өөрсдийгөө онлайн орчинд баталгаажуулах шинэ технологид нээлттэй хандах болжээ. Саяхан хийгдсэн IBM-ын Аюулгүй байдлын судалгаанд оролцогчид өөрийн хэрэглэдэг ихэнх аппликэшндээ хэрэглэхэд таатай байх гэдэг хүчин зүйлээс илүүтэйгээр аюулгүй байдлыг илүүд үзнэ гэдгээ илэрхийлсэн байна.

Биометрик, олон хүчин зүйлийн баталгаажуулалт (MFA) мөн нууц үг удирдах шийдэл зэрэг шийдлүүд илүү боловсронгуй болсон ба үүнийг дагаад хэрэглэгчид ч гэсэн өөрийгөө баталгаажуулахдаа зөвхөн нууц үгэнд суурилсан баталгаажуулалт ашиглахаа больж, шинэ шийдэл рүү шилжээд эхэлчихсэн байна. IBM-ын судалгааны үр дүнд баталгаажуулалтын хуруу унших шийдэл нь баталгаажуулалтын хамгийн эрсдэл багатай шийдэлд тооцогджээ. Түүнээс гадна хэрэглэгчдийн 67 хувь нь өнөөдрийн байдлаар биометрик баталгаажуулалтыг хэрэглэж байгаа бол 87 хувь нь ирээдүйд энэ төрлийн баталгаажуулалтад нээлттэй хандахаа илэрхийлжээ.

Өнөөдөр АНУ-ын ажиллах хүчний ихэнх хэсгийг бүрдүүлж буй (Миллениалууд) энэхүү өөрчлөлтийн тэргүүн эгнээг эзэлж байна. Хэрэглэхэд хялбархан байдаг тул шинэ үеийн залуучууд биометрик шийдлийг илүү ихээр хэрэглэх хандлагатай байна. Түүнээс гадна, эдгээр залуу үеэс хоёр дахин илүү ахмад үеийнхэн (55-аас дээш насны) өөрсдийн интернет хаягийг хамгаалахдаа нууц үг удирдах шийдэл ашиглаж байна.

“Today” нь ирээдүйн баталгаажуулах механизмд анхаарал хандуулж байна.

Саяхан NBC-ийн Том Костелло IBM-ын X-Force экспертүүдтэй Массачусетс дэх Кембриджид Кибер Рэйнж-д уулзсан ба энэхүү уулзалтын үеэр яагаад зөвхөн нууц үгээс хамаарсан баталгаажуулалтын механизм хуучирсан болох мөн ирээдүйд интернет орчинд бид өөрсдийгөө хэрхэн баталгаажуулж болох талаар хэлэлцжээ.